Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газар нь 2020 онд харьяа орон нутаг дахь Баянхонгор аймгийн Политехник коллежийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй байна.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны 3 дугаар улирлын санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшин “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшин 2020 оны 3 дугаар улирлын нийт зардлын 1,665,802.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 33,316.0 мянга, гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшин 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлын 2,584,809.4 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 25,848.1 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж баталгаажууллаа.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Баянхонгор аймгийн Политехникийн коллежийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн 2,967,820.8 мянга өмнөх оноос 96,697.9 мянган төгрөгөөр буюу 3.1 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|--|-------------------|--------------------|-------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 382,485.8 | 365,248.1 | (17,237.7) |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 11,942.1 | 2,515.1 | (9,427.0) |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 370,543.7 | 362,733.0 | (7,810.7) |
| ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 2,682,032.9 | 2,602,572.7 | (79,460.2) |
| Үндсэн хөрөнгө | 4,147,796.3 | 4,415,963.6 | 268,167.3 |
| Хуримтлагдсан элэгдэл | (1,465,763.4) | (1,813,390.9) | (347,627.5) |
| Нийт хөрөнгө | 3,064,518.7 | 2,967,820.8 | (96,697.9) |
| Өр төлбөр | - | - | - |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 3,064,518.7 | 2,967,820.8 | (96,697.9) |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 3,064,518.7 | 2,967,820.8 | (96,697.9) |

Авлага дансны үлдэгдэл 2,515.1 мянган төгрөг болж 9,427.0 мянган төгрөгөөр буурсан нь дотуур байрны хүүхдийн хоол, хүнсний материалыг бэлтгэн нийлүүлэгч

“Хонгор хайрханы сүлд” ХХК-д 4867.5 мянган төгрөгийг илүү шилжүүлж авлагаар тусгасныг Төрийн аудитын байгууллагаас хийгдсэн 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар акт тогтоосныг төлсөн, жолооны курсийн сурагчдын сургалтын төлбөрийн авлага 3,400.0 мянган төгрөгийг барагдуулсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 362,733.0 мянган төгрөг болж 7810.7 мянган төгрөгөөр буурсан нь тусгай зориулалтын материал 1,354.5 мянга, бичиг хэргийн материал 2,299.0 мянга, аж ахуйн материал 4,308.8 мянга, барилгын засварын материал 5,096.8 мянган төгрөг тус тус буурсантай холбоотой байна.

Энэ нь Төрийн аудитын байгууллагаас хийсэн 2019 оны санхүүгийн тайлангийн аудитаар бараа материалыг нөөцлөхгүй байх, бараа материалын үлдэгдлээс зарцуулах зөвлөмж өгсний дагуу урд оны үлдэгдлээс зарцуулсантай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 4,415,963.6 мянган төгрөг болж 268,167.3 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 10,050.0 мянга, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамнаас Азийн хөгжлийн банкны санхүүжилтээр “Хөдөлмөр эрхлэх ур чадвар дээшлүүлэх төсөл”-ийн хүрээнд зөөврийн компьютер, принтер, телевизор 19,503.0 мянга, авто машин засвар ашиглалтын мэргэжлийн ангийн дадлага сургалтад ашиглагдах 55 нэр төрлийн 226,367.4 мянга, Барилгын засал чимэглэл, эрчим хүчний хэмнэлттэй барилгын бүтээц, хуурай хийц” төслийн хүрээнд барилгын засал чимэглэгч мэргэжлийн ангийн дадлагын сургалтад ашиглагдах 155 нэр төрлийн 19,862.8 мянга, нийт 265,733.2 мянган төгрөгийн хөрөнгө орлого авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,967,820.8 мянган төгрөг болж 96,697.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгийн өөрчлөлтөөс шалтгаалжээ.

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого 2,488,111.5 мянган төгрөг болж өмнөх оноос 495,117.2 мянган төгрөгөөр буюу 24.8 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 495,117.2 мянган төгрөгийн орлого байна. Энэ нь улсын төсвийн санхүүжилт 266,192.4 мянга, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 251,135.6 мянга, үндсэн үйл ажиллагааны орлого 1599.6 мянган төгрөгөөр өссөнөөс шалтгаалжээ.

Нийт зардал 2,584,809.4 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 298,200.4 мянган төгрөгөөр буюу 13.0 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд байна. Энэ нь цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, НДШ, түлш халаалт, цэвэр бохир ус, бичиг хэрэг, тээвэр шатахуун, хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал, бага, үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс, нормын хувцас зөөлөн эдлэлийн зардал өссөнтэй холбоотой байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,186,078.2 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2,186,078.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 99,810.6 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 2,285,888.8 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөр 3 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,191,400.1 мянган төгрөгийн төсөв баталснаас 2,160,400.1 мянган төгрөгийг улсын төсвөөс, 25,500.0 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлогоос, 5,500.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,160,400.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагааны орлого 12,057.8 мянга, туслах үйл ажиллагааны орлого 2,466.0 мянга төгрөгийг оруулж, нийт 2,174,923.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 1,939,676.8 мянган төгрөгийг зарцуулж, 235,247.1 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,939,676.8 мянган төгрөг буюу 88.5 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшил 126,531.5 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 30,172.2 мянга, байр ашиглахтай холбоотой зардал 19,045.7 мянга, хангамж, бараа материалын зардал 1,499.0 мянга, хоол, хүнс 74,839.3 мянга, нормын хувцас, зөөлөн эдлэл 25.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр 1,237.0 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшуулал 109.5 мянган төгрөгөөр тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

**Баянхонгор аймгийн Политехникийн коллежийн 2020 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

/төгрөгөөр/

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Төсвийн гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|--|-------------------------|-------------------------|-----------------------|--------------|
| ХӨТӨЛБӨР 71804 | | | | |
| АРГА ХЭМЖЭЭ 80101 | | | | |
| НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 2,191,400,100.00 | 1,939,676,848.20 | 251,723,251.80 | 88.51 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 2,191,400,100.00 | 1,939,676,848.20 | 251,723,251.80 | 88.51 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,191,400,100.00 | 1,939,676,848.20 | 251,723,251.80 | 88.51 |
| Цалин, хөлс болон нэмэгдэл | 1,299,628,800.00 | 1,173,097,260.33 | 126,531,539.67 | 90.26 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 175,449,800.00 | 145,277,618.87 | 30,172,181.13 | 82.80 |
| Байр ашиглалттай холбоотой | 406,712,500.00 | 387,666,759.00 | 19,045,741.00 | 95.32 |
| Хангамж, бараа материалын | 27,082,200.00 | 25,583,177.00 | 1,499,023.00 | 94.46 |
| Нормативт зардал | 16,770,400.00 | 16,745,400.00 | 25,000.00 | 99.85 |
| Томилолт, зочны зардал | 640,000.00 | 640,000.00 | 0.00 | 100.00 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 12,591,000.00 | 11,353,943.00 | 1,237,057.00 | 90.18 |
| Хичээл үйлдвэрлэлийн дадлага | 51,599,900.00 | 53,336,010.00 | -1,736,110.00 | 103.36 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 122,090,100.00 | 121,980,580.00 | 109,520.00 | 99.91 |
| Бусад урсгал шилжүүлэг | 122,090,100.00 | 121,980,580.00 | 109,520.00 | 99.91 |
| Тэтгэвэрт гарахад олгох нэг | 12,608,900.00 | 12,608,900.00 | 0.00 | 100.00 |
| Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,968,000.00 | 1,858,480.00 | 109,520.00 | 94.43 |
| Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан | 107,513,200.00 | 107,513,200.00 | 0.00 | 100.00 |
| НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР | 78,835,400.00 | 3,996,100.00 | 74,839,300.00 | 5.07 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 78,835,400.00 | 3,996,100.00 | 74,839,300.00 | 5.07 |
| БАРАА, АЖИЛ | 78,835,400.00 | 3,996,100.00 | 74,839,300.00 | 5.07 |
| Хоол, хүнс | 78,835,400.00 | 3,996,100.00 | 74,839,300.00 | 5.07 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 2.5-д харуулав.

Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлого

2020 онд үндсэн үйл ажиллагааны орлого 25,500.0 мянган төгрөгийн орлого батлагдсанаас гүйцэтгэлээр 12,057.9 мянга, туслах үйл ажиллагааны орлого 5,500.0 төгрөгийн орлого батлагдсанаас 2,466.0 мянган орлогыг бүрдүүлж, төлөвлөгөөг 53.2 хувиар тасалсан байна.

Хүснэгт 2 Төсөвт байгууллагын орлого

/мянган төгрөг/

| Орлогын төрөл | Төлөв | Гүйц | Зөрүү | Хувь |
|-------------------------------|-----------------|-----------------|-----------------|-------------|
| Үндсэн үйл ажиллагааны орлого | 25,500.0 | 12,057.9 | 13,442.1 | 47.2 |
| Туслах үйл ажиллагааны орлого | 5,500.0 | 2,466.0 | 3,034.0 | 44.8 |
| Нийт дүн | 31,000.0 | 14,523.9 | 16,476.1 | 46.8 |

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангаас мэргэжлийн сургалтын зардалд 5,580.0 мянга, “Монгол даатгал” ХХК-аас даатгалын төлбөрт 445.5 нийт 6,025.5 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс насанд хүрэгчдэд мэргэжил олгох оёдол, эсгүүрийн түр сургалт, тогоочийн түр сургалтын зардалд 5,580.0 мянга, хичээлийн 2 дугаар байрны урсгал засварт 445.5 мянга нийт 6,025.5 мянган төгрөгийг зарцуулсан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 144 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроож байршуулсан 5 мэдээлэл байна. Үүнд төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, хагас жилийн санхүүгийн тайлан, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт зэрэг орлогын 1 гүйлгээний 164537.3 мянга, зарлагын 3 гүйлгээний 56665.9 мянган төгрөгийн мэдээллүүдийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Цалингийн сангаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ байршуулсан эсэхийг хянаж үзэхэд орлогын 21 гүйлгээний 2,168,657.7 мянга, зарлагын 16 гүйлгээний 527,179.7 мянган төгрөгийн мэдээллийг бүрэн байршуулсан..

| д/д | Хугацаа | Төрөл | Удаа | Хугацаанд нь байршуулсан | Хугацаа хоцроож байршуулсан | Байршуулаагүй | Хугацаа болоогүй |
|-----|------------|-------|------|--------------------------|-----------------------------|---------------|------------------|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 7 | 2 | | 2 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 3 | 1 | | |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 4 | | | |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 35 | 1 | | |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 95 | 1 | | |
| 6 | Нийт | 27 | 151 | 144 | 5 | | 2 |

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 14,122.1 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт, 26,219.7 мянган төгрөгийн зөрчилд зөрчил давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн байна.

Аудитаар өгсөн 26,219.7 мянган төгрөгийн зөвлөмжийн хэрэгжилтийг Баянхонгор аймгийн Политехник коллежийн захирлын 2020.06.29 өдрийн 76 тоот албан бичгээр хариуг ирүүлсэн ба биелэлт 95.7 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

| Үзүүлэлт | Өмнөх оны илрүүлэлт | | Биелэлт | | Зөрүү | | |
|-----------------|---------------------|----------|---------|----------|-------|---------|------|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Акт | 7 | 14,122.1 | 7 | 14,122.1 | | | |
| Албан шаардлага | | | | | | | |
| Зөвлөмж | 6 | 26,219.7 | 5 | 24,469.7 | 1 | 1,750.0 | 4.3 |
| Нийт дүн | 13 | 40,341.8 | 12 | 38,591.8 | 1 | 1,750.0 | 4.3 |

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 62,147.6 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 400.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт, 16,250.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 45,497.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Санхүүгийн тайланд халаалтын өглөг тусгаагүй байхад 2020.02.18-ны өдөр "Марал гүн" ХХК-д 44021.7 мянган төгрөгийг өмнөх онуудын халаалтын төлбөрийн үлдэгдэл гэж 2 сарын төлбөр дээр нэмж нийт 85597.6 мянган төгрөгийг нэхэмжилснийг шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4. "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Үнэн зөв байх", 14 дүгээр зүйлийн 14.4. Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.3. "Бүх өр төлбөр" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд авлагаар бүртгэж залруулав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 16,650.0 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 16,250.0 мянган төгрөгийн 1 албан шаардлага, 400.0 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн актыг тогтоолоо. Үүнд:

1. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2020.04.21-ны өдрийн 146 дугаар тогтоолоор жолооны сургалтад ашиглагдаж байсан 2 автомашины дуудлага худалдаагаар худалдах доод үнийг 400.0 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоож өгсний дагуу дуудлага худалдааг зохион байгуулсан боловч дуудлага худалдаанд

оролцох хүсэлт ирээгүй тул Политехникийн коллежийн өмч хамгаалах зөвлөлийн 2020.09.14 -ны өдрийн 03 дугаар хурлын шийдвэрээр эзэмшиж байсан жолооч нарт худалдах доод үнээр худалдахаар тогтоож төлбөрийг байгууллагын төсөвт 400.0 мянган төгрөгийг төвлөрүүлж зарцуулсан байна

Энэ нь Төрийн өмчийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1."Төрийн өмчит хуулийн этгээд эзэмшилдээ байгаа илүүдэл үндсэн эд хөрөнгө, түүнчлэн ашиглах хугацаа нь дууссан буюу эсхүл осол гэмтэлд өртсөний улмаас зориулалтаар нь ашиглах боломжгүй болсон бөгөөд засаж, сэлбэж ашиглах нь эдийн засгийн хувьд үр ашиггүй нь тооцоогоор нотлогдсон эд хөрөнгийг худалдаж, шилжүүлж, акт тогтоон устгаж болно.", Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын, 2020.04.21-ны өдрийн 146 дугаар тогтоолын 2.2. " Дуудлага худалдааг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсэг байгуулах, дуудлагын худалдаанаас олох орлогыг (дуудлагын худалдааны зардлыг хассан дүнгээр) зохих журмын дагуу улсын төсөвт төвлөрүүлэх гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төлбөрийн акт тогтоох

2. Санхүүгийн тооцоолох компанийн 1750.0 мянган төгрөгийн өртөгтэй санхүүгийн программтай бөгөөд нягтлан бодох бүртгэлийн Ахplorer программ ашиглах болсонтой холбоотой ашиглахгүй байгааг холбогдох газар хандаж шийдвэрлүүлээгүй байна. Мөн мэдээллийн нэгдсэн системийн 14500.0 мянган төгрөгийн өртөгтэй e-TVET цахим программ хүчин чадал нь хүрэхгүй байгаа тул ашиглахгүй байгаа гэсэн тайлбарыг сургалтын менежер өгөв.

Энэ Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4. Үнэн зөв байх, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020.12.09-ны өдрийн А/95 дугаар тушаалын "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.10. "Аудитаар илэрсэн алдаа, зөрчил, түүнийг арилгахаар өгсөн зөвлөмжийг хугацаанд хэрэгжүүлээгүй бол" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага өгөх

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн алдаа зөрчлийг, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.9. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Аудитыг цаг хугацааны хомсдолтой нөхцөлд гүйцэтгэсэн тул Санхүүгийн тайланд халаалтын өглөг тусгаагүй байхад 2020.02.18-ны өдөр "Марал гүн" ХХК-д 44021.7 мянган төгрөгийг өмнөх онуудын халаалтын төлбөрийн үлдэгдэл гэж 2 сарын төлбөр дээр нэмж нийт 85597.6 мянган төгрөгийг нэхэмжилснийг шилжүүлсэн асуудлыг дараах байдлаар анхаарч үзэх:

- 2021 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөөнд тусгагдсан "Төсөвт байгууллагуудын халаалтын зардлын төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл"-д хийх нийцлийн аудитаар нарийвчлан шалгах шаардлагатай.

- Өмнөх онд ААНБ-тай байгуулсан халаалтын гэрээ, нэхэмжлэхэд төсөвт байсан дүнгээр сар бүр нэхэмжилсний дагуу төлж тайланд өглөггүй гэж тусгасан атлаа 2020 онд өглөгтэй гэж төсөвт суулгаж дээрх мөнгийг төлсөн байгааг Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар хянан үзэж дүнгээ 2021 оны 05 дугаар сарын 01-ны дотор хариуг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт албан тоотой ирүүлэх.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1.Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл

1.1 Илрүүлэлт

Санхүүгийн тайланд халаалтын өглөг тусгаагүй байхад урд онуудын халаалтын өр 44021.7 мянган төгрөгийг 2020.02.18-ны өдөр "Марал гүн" ХХК-д шилжүүлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4."Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д "Үнэн зөв байх", 14 дүгээр зүйлийн 14.4.Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ: 14.4.3."Бүх өр төлбөр" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

1.2. Эрсдэл

Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах.

1.3 Өгсөн зөвлөмж

Харилцагч байгууллагуудтай хийх төлбөрийн тооцоог цаг тухай бүрд нь хийж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулан бүртгэлийг үнэн зөв хөтөлж, тайланд авлага, өглөгийг бүрэн тусгаж Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах.

1.4.Байгууллагаас өгсөн хариу тайлбар

2. Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

2.Зардлын данстай холбоотой

2.1 Илрүүлэлт

Цалин, НДШ, ХХОАТ-ын тооцооллыг шалгахад дараах зөрчил илэрлээ: Үүнд: Цалингийн зардлыг 178.7 мянган төгрөгөөр үр дүнгийн тайланд дутуу илэрхийлсэн, бараа ажил үйлчилгээний ХХОАТ-ыг суутгаж авсан атлаа цалингийн сангаас 68.7 мянган төгрөгийг төлсөн, НДШ-ийн 418.5 мянган төгрөгийг тайлант онд дутуу төлсөн нь өмнөх оны тэтгэвэр тогтоолгон ажиллаж байгаа ажилчдын НДШ-ийн мэдээг илгээхдээ "Тайлан шалгах" цэс ашиглаагүйгээс тооцоололд зөрүү гарсныг Нийгмийн даатгалын хэлтэс залруулга хийж суутган тооцсонтой холбоотой байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах Сангийн сайдын 2014 оны "Эдийн засгийн ангилал" батлах тухай 55 дугаар тушаалын 6 дугаар хавсралтаар батлагдсан "Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар"-ын "Цалин хөлс ба нэмэгдэл

урамшил”, “Ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл” гэсэн эдийн засгийн ангилал, Нийгмийн даатгалын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 6 дахь заалтад “Ажил олгогч иргэнтэй байгуулсан хөдөлмөрийн гэрээ болон Иргэний хуулийн 343, 359 дүгээр зүйлд заасан гэрээний дагуу ажиллаж байгаа тэтгэвэр авагч энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3, 5 дахь заалтад зааснаас бусад төрлийн даатгалд албан журмаар даатгуулна” тус тус зөрчсөн байна.

2.2. Эрсдэл

Цалин, НДШ, ХХОАТ-ын зардлыг илүү дутуу тооцох

2.3 Өгсөн зөвлөмж

Цалин, нийгмийн даатгалын шимтгэл, ХХОАТ-ыг тухай бүр үнэн мэдээлж, суутгасан татварыг хугацаанд нь төлж, Нийгмийн даатгалын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1.Хөдөлмөрийн хөлсний сан, түүнтэй адилтгах орлого болон түүнд оногдох шимтгэлийг үнэн зөв тодорхойлж, тогтоосон хугацаанд төлөх” гэсэн заалтыг мөрдөж ажиллах.

2.4.Байгууллагаас өгсөн хариу тайлбар

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

3.Балансын данстай холбоотой асуудал

3.1 Илрүүлэлт

Бичиг хэргийн зардлаас 810.0 мянган төгрөгийн дэвтэр, бал авч захирлын тушаал шийдвэргүйгээр багш нарт шаардахаар багш нарын баяраар шагналд олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5.”Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.2. Эрсдэл

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулаагүй байх

3.3 Өгсөн зөвлөмж

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулж Сангийн сайдын 2014 оны “Эдийн засгийн ангилал” батлах тухай 55 дугаар тушаалын 6 дугаар хавсралтаар батлагдсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар”-ын “Бичиг хэрэг” эдийн засгийн ангиллыг мөрдөж ажиллаж төсөвт тусгагдаагүй зардлыг шийдвэргүйгээр зориулалт бусаар санхүүжүүлэхгүй байх.

3.4.Байгууллагаас өгсөн хариу тайлбар

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

4.Тайлант хугацаанд хэрэгжүүлэх ерөнхий чиглэл

4.1 Илрүүлэлт

Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 144 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроож байршуулсан 5 мэдээлэл байна. Үүнд төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ, хагас жилийн санхүүгийн тайлан, хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт зэрэг орлогын 1 гүйлгээний 164537.3 мянга, зарлагын 3 гүйлгээний 56665.9 мянган төгрөгийн мэдээллүүдийг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” 6.4 “ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

4.2. Эрсдэл

Хуульд заасан мэдээллийг байршуулаагүй байх

4.3. Өгсөн зөвлөмж

Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ”, 6.4 “ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсний дагуу орлого, зарлагын мэдээллийг хугацаанд мэдээлж байх.

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар

Зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллана

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 04 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР

АНХАН ШАТАНД ХЯНАСАН:

АУДИТЫН МЕНЕЖЕР

ХОЁР ДАХЬ ШАТАНД ХЯНАСАН:

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Н.БҮНЧИНСҮРЭН
ОГНОО: 2021.02.10

А.ЦЭЭНЯМ
ОГНОО: 2021.02.10

Б.МӨНХБАТ
ОГНОО: 2021.02.10

5. Хавсралт: Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| | | | |
|------------------------------|--------------------------------------|--|----------------------|
| Огноо: | Аудитын нэр: | 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит | Аудитын код: |
| 2021 | | | БНА-2021/169/СТА-ТШЗ |
| Шалгагдсан байгууллагын нэр: | Баянхонгор аймгийн Политехник коллеж | | Мянган төгрөг |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|------------|--|-----------------|---------------------------------------|---|------------------------------|
| | | | Нэр | Албан тушаал | Овог нэр |
| | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Автомашин дуудлага худалдааны 400.0 мянган төгрөгийг байгууллагын төсөвт төвлөрүүлж зарцуулсан байна. | 400.0 | Төлбөрийн акт тогтоох | Захирал Нягтлан бодогч | Д.Бат-Орших Ц.Цэвээнсүрэн |
| 2 | Санхүүгийн тайланд халаалтын өглөг оны эхэнд тусгаагүй байхад 2020.02.18-ны өдөр "Марал гүн" ХХК-д 44021.7 мянган төгрөгийг өмнөх онуудын халаалтын төлбөрийн үлдэгдэл гэж тайлант хугацааны зардал дээр нэмж шилжүүлсэн бөгөөд энэ нь баримтаар нотлогдохгүй байгаа тул санхүүгийн тайланд залруулав. | 44,021.7 | Санхүүгийн тайланд авлагаар залруулах | Захирал Нягтлан бодогч | Д.Бат-Орших Ц.Цэвээнсүрэн |
| 3 | Цалин, НДШ, ХХОАТ-ын тооцооллыг давтан шалгахад цалингийн зардал 178.7 мянга, ХХОАТ 68.7 мянга, НДШ-ийн 418.5 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй байна | 665.9 | Зөвлөмж өгөх | Захирал Нягтлан бодогч | Д.Бат-Орших Ц.Цэвээнсүрэн |
| 4 | Багш нарын баярын 810.0 мянган төгрөгийн шагналыг бичиг хэргийн зардлаас олгосон байна. | 810.0 | Зөвлөмж өгөх | Захирал Нягтлан бодогч | Д.Бат-Орших Ц.Цэвээнсүрэн |
| 5 | Тайлант хугацаанд оруулбал зохих 151 мэдээллээс 5 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна. | | Зөвлөмж өгөх | Захирал Нягтлан бодогч | Д.Бат-Орших Ц.Цэвээнсүрэн |
| 6 | Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар ашиглалтгүй 1750.0 мянган төгрөгийн өртөгтэй санхүүгийн программ, 14500.0 мянган төгрөгийн өртөгтэй e-TVET цахим программыг холбогдох хууль дүрмийн дагуу арга хэмжээ авах зөвлөмжийг өгсөн боловч хэрэгжүүлж ажиллаагүй байна. | 16,250.0 | Албан шаардлага өгөх | Захирал Нягтлан бодогч | Д.Бат-Орших Ц.Цэвээнсүрэн |
| ДҮН | | 62,147.6 | | | |